

ТОЙМ



**ОЛОН УЛСЫН
ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

2025.01.13

Голомт Капитал ҮЦК-д бэлтгэв

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- АНУ-ын ХНС бодлогын хүүг яаран бууруулахгүй
- АНУ-ын инфляцын мэдээ 1-р сарын 15-нд гарах бөгөөд 2.9% болж өсөх хүлээлттэй байна.
- Банк, санхүүгийн салбарын компаниудын тайлангууд зарлагдаж эхэлж байна.
- Хятадад дефляцын дарамт үргэлжилж байна.
- Хятадын Төв банк: Хөрвөх чадварыг хангахын тулд хүүгийн түвшин, заавал байлгах нөөц ашиглана

2025 он 01-р сарын 13

Dow Jones	41,938.45
S&P 500	5,827.00
Nasdaq	19,161.63
DAX	20,214.79
FTSE 100	8,248.49
S&P/ASX 200	8,187.20
HANG SENG	18,844.00

АНУ-ын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
Dow Jones	-1.63%	-1.80%	-4.31%	-1.42%	11.56%	16.78%
S&P 500	-1.54%	-2.48%	-3.70%	-0.93%	21.81%	24.97%
Nasdaq	-1.63%	-3.54%	-3.84%	-0.77%	27.98%	28.66%

2025 оны 01 сарын 13-ны 11:00

Европын индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
DAX	-0.50%	-0.01%	-0.94%	1.54%	21.01%	27.27%
FTSE 100	-0.50%	-0.01%	-0.62%	0.92%	8.18%	9.35%

2025 оны 01 сарын 13-ны 11:00

Ази Номхон далайн индексийн өгөөж

Индекс	Өдрийн	Долоо хоног	Сар	Жилийн эхнээс	Жил	3 жил
S&P/ASX 200	-1.28%	-0.89%	-1.35%	0.30%	9.14%	10.68%
Hang Seng	-1.18%	-4.17%	-5.53%	-5.95%	16.14%	-22.62%

2025 оны 01 сарын 13-ны 11:00

S&P 500 индексийн
2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Wells Fargo	6,500
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678



Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өнгөрсөн долоо хоногт уналаа. Nasdaq Composite индекс 2.34%-иар буурч, 11-р сараас хойш байгаагүй хүчтэй долоо хоногийн уналтыг харуулаад байна. Шинэ Трампын засаг захиргаа тарифын талаар зөөлөн бодлого баримтлах тухай мэдээлэл гарсны дараа долоо хоногийн эхэнд индексүүд өсөлттэй эхэлсэн. Гэсэн ч долоо хоногийн сүүлээр Трамп энэ мэдээллийг няцааснаар, мөн инфляцтай холбоотой эдийн засгийн мэдээлэл олон нийтэд хүрснээр зах зээлд өөдрөг байдал алдарсан.

Ажил эрхлэлтийн тайлан

12 дугаар сард 256,000 шинэ ажлын байр бий болсон нь эдийн засагчдын тооцоолж байсан 165,000 ажлын байрнаас хамаагүй өндөр байсны зэрэгцээ ажилгүйдлийн түвшин 4.1% болж буурсан байна. Энэ тайлан нь хөдөлмөрийн зах зээл тогтвортой байгааг харуулсан бөгөөд Холбооны нөөцийн сангийн хүүгийн бууралтын хурдац удааширна гэсэн хүлээлтийг баталгаажуулжээ.

ХНС хүүгээ яаран бууруулахгүй

1-р сарын 28-нд хүүг бууруулах магадлал ердөө 5% байгаа бол 3-р сард болох хуралдаанаар хүүг бууруулах магадлал 25% байна. Үүнээс шалтгаалан баасан гарагт зах зээл унаж, S&P 500 1.5 орчим хувиар уналаа. Мөн энэ долоо хоногт 1-р сарын 15-нд 12-р сарын инфляцын мэдээ гарах бөгөөд эдийн засагчид жилийн 2.9%-ийн өсөлттэй гарах төлөвтэй байна гэж таамаглаж байна.

Холбооны нөөцийн сан 9-р сард инфляц хангалттай хэмжээнд буурч эхэлсэн тул хүү бууруулахад бэлэн болсон гэж үзэж байсан ч жилийн инфляцын өсөлт тус сангийн 2%-ийн зорилтот түвшнээс өндөр хэвээр байгаа. Холбооны нөөцийн сан одоо 2025 онд инфляц 2.5%-д хүрч өснө гэж төсөөлж байна.

График 1: АНУ-ын S&P500 индексийн ханшийн таамаглал





Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Хятадын хувьцааны уналт: Дефляцын дарамт үргэлжилж байна

Хятадын эдийн засгийн үзүүлэлтүүд дефляц үргэлжилж байгааг харуулснаар Хятадын хувьцааны зах зээл буурлаа.

- Шанхайн нэгдсэн индекс 1.34%-иар унасан.
- CSI 300 индекс 1.13%-иар буурсан.
- Хонгконгийн Hang Seng индекс 3.52%-иар буурав.

Инфляцын үзүүлэлтүүд

- Хэрэглээний үнийн индекс (CPI): 12-р сард 0.1% өссөн нь 11-р сарын 0.2% өсөлтөөс буурсан. Энэ нь хүнс, түлшний үнэ буурсантай холбоотой.
- Үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI): Жил бүрийн үзүүлэлтээр 2.3% буурсан нь өмнөх сарын 2.5%-ийн уналтаас бага боловч энэ нь үйлдвэрүүдийн борлуулалтын үнийн дефляц 27 сар дараалан үргэлжилж байгааг харууллаа.

Хятадын Төв банкны мэдэгдэл

Хятадын Ардын банк (PBOC) улирлын бодлогын хурлын дараа дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээ мэдэгдсэн:


- Зөөлөн мөнгөний бодлого: Эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор зөөлөн бодлого үргэлжлүүлнэ.
- Санхүүгийн дэмжлэг: Технологи, хүлэмжийн хий бууруулах шийдэл, тэтгэврийн сан, дижитал салбар зэрэгт дэмжлэг нэмэгдүүлнэ.
- Хүү болон заавал байлгах нөөцийн бууралт: Хэрэглээг идэвхжүүлэх зорилгоор шаардлагатай үед хүүгийн түвшин болон заавал байлгах нөөцийн харьцааг бууруулна.

Хэдийгээр Хятадын эдийн засагт дефляцын дарамт үргэлжилж байгаа ч үйлчилгээний салбарын өсөлт болон Төв банкны дэмжлэгийн бодлого ирэх саруудад сэргэлтийн хүлээлтийг нэмэгдүүлж байна. Гэсэн хэдий ч инфляцын сул үзүүлэлт нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сулруулж, зах зээл уналтад орсон хэвээр байна.

График 2: Hang Seng индексийн ханшийн таамаглал


















abigun published on TradingView.com, Nov 25, 2024 12:10 UTC+8

HS0000, 1D C19,307.34 H19,351.06 L19,102.70 C19,131.82 -98.15 (-0.51%)



ЭНЭ ДОЛОО ХОНОГИЙН ОНЦЛОХ ТАЙЛАНГУУД

Хүснэгт 1: Энэ долоо хоногт зарлагдах онцлох мэдээнүүд

E EARNINGS W WHISPERS					Most Anticipated Earnings Releases				
					for the week beginning				
					January 06, 2025				
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
									
									
									
									
									
									
									
									
									
									
									
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers	

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS W WHISPERS					Most Anticipated Earnings Releases				
					for the week beginning				
					January 13, 2025				
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
									
									
									
									
									
									
									
									
									
									
									
									
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers	